

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 25/1

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр ээлжит бус хуралдааныг хийж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдаанаар эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөв, бодлогын саналыг Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулж, хэлэлцүүлэв.

Хуралдааны эхний хэсэгт эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийн талаар танилцуулав. Инфляц 2024 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд 9.0 хувь, Улаанбаатар хотод 9.1 хувьтай гарлаа. Инфляц ийнхүү нэмэгдэхэд цахилгаан, мах болон импортын барааны үнэ хүлээлтээс давж өссөн нь голлон нөлөөлөв. Дотоод эрэлт, цалингийн өсөлтийн нөлөөгөөр үйлчилгээ, түрээсийн үнэ өндөр өсөлттэй байна. Ийнхүү эрэлтийн шалтгаантай үнийн дарамт хүлээлтээс эрчимжсэн, өрхийн цахилгааны төлбөр анх мэдэгдэж, тооцоонд авсан байснаас өндрөөр өссөн, Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ногдол ашиг хуваарилах зэрэг эрэлт болон зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц өмнөх төсөөллөөс нэмэгдэж, энэ оны 2, 3 дугаар улиралд 10 хувийг давж эрчимжин, оны сүүлээс алгуур буурахаар байгааг танилцууллаа.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны сарын туршилтын мэдээгээр эдийн засаг 2024 оны эхний 11 сард 4.7 хувиар өссөн. Нүүрсний олборлолт оны эхнээс 90 сая тоннд хүрч, уул уурхайн салбарын үйлдвэрлэл эхний 11 сард 10.5 хувиар өслөө. Эдийн засгийн идэвхжил, импортын өсөлттэй холбоотойгоор үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татварын өсөлт нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Харин улсын хэмжээнд 9.3 сая толгой мал зүй бусаар хорогдож, хөдөө аж ахуйн салбар эхний 11 сард 25.7 хувиар агшсан нь эдийн засгийн өсөлтөд 3.4 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг энэ удаад хэвээр хадгалсан хэдий ч, сарын тоо мэдээллээс харахад уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт 2024 оны 4 дүгээр улиралд хүлээлтээс бага гарч, үйлчилгээний салбарын идэвхжил бага зэрэг саарсан зэргээс шалтгаалан өсөлт төсөөллөөс доогуур гарахаар байгааг танилцуулав.

Төсвийн тэнцэл 2024 оны эхний 11 сард 1.4 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн орлого бүрдүүлэлт сайн байж, төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 5.4 их наяд төгрөгөөр өссөн бол төсвийн зардал өмнөх оноос 6 их наяд төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Төсвийн шаардлагатай санхүүжилт эхний 11 сарын байдлаар 777 тэрбум төгрөг байгаа бөгөөд төсвийн тэнцэл ашигтай байж, ойрын хугацаанд хийгдэх гадаад өр төлбөрүүдээ төлж, төсвийн санхүүжилтийн үзүүлэлт хэвийн түвшинд байгааг дурдлаа.

M2 мөнгөний жилийн өсөлт 2024 оны 11 дүгээр сард 17.2 хувьд хүрч саарлаа. Үүнд, гадаад цэвэр активын өсөлт саарч, Нийслэлийн бондын төлбөрийг төв банканд байршуулсантай холбоотойгоор засгийн газрын цэвэр зээл буурсан нь голлон нөлөөлөв. Нөгөө талаас, банкны салбарын зээлийн жилийн өсөлт 11 дүгээр сард 30.6 нэгж хувьд хүрч, M2 мөнгөний өсөлтийг дэмжсэн хэвээр байна. Үүн дотроо, бизнесийн зээлийн өсөлт өндөр түвшинд хадгалагдсан бөгөөд уул уурхай, худалдаа, үйлчилгээ, тээврийн салбаруудын зээл олголт нэмэгдсэн дүнтэй байна.

Гадаад орчин, төлбөрийн тэнцлийн нөхцөл байдлыг танилцуулав. Гадаад худалдааны гүйцэтгэлийг авч үзвэл нийт экспорт 2024 онд 4 хувиар, импорт 26 хувиар тус тус өслөө.

Нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх онтой харьцуулахад 20 орчим хувиар нэмэгдсэн хэдий ч хилийн үнэ 14 орчим хувиар буурснаар экспортын орлогын өсөлт эрчтэй саарлаа. Харин төмрийн хүдрийн биет хэмжээ өсөж, алт, зэсийн үнэ өндөр хадгалагдсан нь нийт экспортыг дэмжив. Эдийн засгийн идэвхжил, төсвийн зардал болон цалингийн өсөлттэй холбоотойгоор хэрэглээ, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр хэвээр байна. Шинээр батлагдсан 2025 оны төсвийн гадаад зээлийн ашиглалт буурсантай уялдан төлбөрийн тэнцлийн төлөв өмнөхөөс муудсаныг танилцуулж, цаашид нүүрсний үнийн хэлбэлзэл томоохон нөлөөтэй байхыг дурдлаа.

Мэдээллийн төгсгөлд МБГ-аас мөнгөний бодлогын саналыг танилцууллаа. Төсөв үргэлжлэн тэлж, ЭТТ ХК-ийн хувьцааны ногдол ашгийг 2024 оны эцэст хуваарилсан, цаашид 2 удаа хуваарилахаар хүлээгдэж байгаа нь өрхийн хэрэглээгээр дамжин инфляцын дарамтыг нэмэгдүүлэхээр байна. Түүнчлэн, цалингийн өсөлтийг даган хэрэглээний зээлийн өсөлт үргэлжлэн эрчимжих, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдах зэргийг харгалзан бодлогын төлөвийг чангаруулж, төгрөгийн болон гадаад валютын ЗБН-ийн хэмжээг тус бүр 2 нэгж хувиар нэмэгдүүлж 13 хувь, 18 хувьд хүргэх, бодлогын хүүг хэвээр хадгалах саналыг танилцуулав. Ингээд МБХ-ны гишүүд асуулт асуун, тодруулга авч бодлогын саналыг хэлэлцлээ.

Нэг гишүүний зүгээс төгрөгийн болон гадаад валютын ЗБН-ийн хэмжээг нэмэгдүүлэх нь бодит эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг тодруулав. Төгрөгийн болон гадаад валютын ЗБН-ийн хэмжээг нэмэгдүүлснээр банкнуудын зээл олгох эх үүсвэрийн хэмжээ буурч, зээлийн өсөлт энэ онд 2.6 нэгж хувиар буурч, эдийн засгийн өсөлт 0.4 нэгж хувиар саарах, улмаар инфляцын дарамтыг 0.7 нэгж хувиар бууруулах тооцоо байгааг танилцууллаа.

Өөр нэг гишүүний зүгээс гадаад валютын эх үүсвэрийн ЗБН-ийн хэмжээг өсгөх шаардлага бий эсэх талаар тодруулав. Харин бусад гишүүдийн зүгээс төсвийн тэлэлт үргэлжилж, нүүрсний хилийн үнэ бууран төлбөрийн тэнцлийн төлөв сайнгүй байхаар байгаа одоогийн нөхцөлд төгрөгийн ЗБН-тэй зэрэгцүүлээд валютын ЗБН-ийн хувь хэмжээг өсгөх нь банкны системийн долларжилтын эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтойг онцоллоо.

Ийнхүү МБХ-ны гишүүд төсвийн зардал болон ЭТТ ХК-ийн хувьцааны ногдол ашиг олголтоос үүдэлтэйгээр мөнгөний нийлүүлэлт, зээл хэт өсөхөөс сэргийлэх зорилгоор мөнгөний бодлогын төлөвийг хатууруулж, банкнуудын төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар тус тус нэмэгдүүлэх нь зүйтэй гэдэгт санал нэгдлээ. Ийнхүү гишүүд бодлогын саналыг 100 хувь дэмжсэнээр Мөнгөний бодлогын хорооны ээлжит бус хурал өндөрлөв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгалах;
2. Банкнуудын төгрөгийн болон гадаад валютын эх үүсвэрийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хувь хэмжээг тус бүр 2 нэгж хувиар нэмэгдүүлж, харгалзан 13 хувь болон 18 хувьд хүргэхээр шийдвэрлэлээ.

Бодлогын саналын шийдвэр

